

МОНГОЛ УЛС БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын <u>19</u> өдөр


Дугаар 1/16


Номгон

-Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 17/59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Баянхонгор аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 230. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1. Үндэсний аюулгүй байдлыг мэдээ мэдээллээр хангах ажлын хэсгийн төлөвлөгөөг нэгдүгээр, Аймгийн хэмжээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 5.0 сая (таван сая) төгрөгийг аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.
- 3.Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухай бүр зохион байгуулж үр дүнг тооцож ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.





ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ МЭДЭЭ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Nº	Зохион байгуулах үйл ажиллагаа	Хугацаа	Тесев	Хүрэх үр дүн	Хариуцах эзэн
1	2	3	4	5	6
		Зохион ба	йгуулалтын	н чиглэлээр	
1	Ажлын хэсгийн шаардлагатай тохиолдолд хуралдуулж чиглэл өгч мэдээлэл солилцох	Жилдээ	500.0 мян/төг	Жилд 2-оос доошгүй удаа хуралдсан байна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Д.Энхжаргал
2	Аймгийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах	Жилдээ	-	Бодлогын баримт бичиг хэрэгжиж эхэлсэн байна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн Ц.Байгальмаа Д.Сарангарав
3	Терийн болон албаны нууцын тухай хууль /Терийн нууц тевлерен хадгалагддаг байгууллагуудад хяналт шалгалт хийж, нууцтай харьцаж буй албан хаагчдад сургалт/ зохион байгуулах	2 дугаар улиралд	1.0 сая/төг	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн Р.Мэндбаяр
	Гадаа	д харилцаа х	амтын ажи	плагааны чиглэлээр	
4	Аймгийн хэмжээнд 2024 онд гадаад арга хэмжээний төлөвлөгөөг Гадаад харилцааны яам болон сангийн яаманд хүргүүлэх	1 дүгээр улиралд	-	Төлөвлөгөөг баталж холбогдох яаманд хүргүүлсэн байна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн П.Отгонбаяр
5	Аймгийн удирдлагууд гадаадад айлчлах, албан хэргээр зорчихдоо албан ёсны	Тухай бүр	-	Удирдамжийг батлуулж чиглэл авсан байна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын

1	2	3	4	5	6
	яриа хэлэлцээ явуулах удирдамжийг ЗГХЭГ-аар батлуулах				ажлын хэсгийн гишүүн П.Отгонбаяр
6	Аймгийн Засаг даргатай гадаад улсын болон олон улсын байгууллагын төлөөлөгч нартай уулзсан ярианы тэмдэглэл, гадаад албан айлчлал арга хэмжээний талаарх илтгэх хуудсыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллах	Тухай бүр	-	ЗГХЭГ, ҮАБЗ-д албан бичгээр хүргүүлсэн байна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн П.Отгонбаяр
	YAБ3-	ийг мэдээ, мэ,	дээллээр х	ангах ажлын хүрээнд	
7	ҮАБЗ-ийг мэдээ, мэдээллээр хангах журмын 1 дүгээр хавсралтын 54, 55 дугаар зүйл 2 дугаар хавсралтад заасан мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газруудаас авч ҮАБЗ-д хүргүүлэх	Тухай бүр	-	Мэдээлэл хугацаандаа мэдээлэгдсэн байна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн Д.Сарангарав
8	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Тухай бүр	-	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Ажлын хэсгийн гишүүд
9	Нутаг дэвсгэрийн хүрээнд Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	-	Соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Ажлын хэсгийн гишүүд
10	Монгол Хэл бичгийн соёлоо хамгаалан хөгжүүлж, уламжлалт монгол бичгийн сургалт сурталчилгааг өргөжүүлж, монгол бичгийн хэрэглээг Төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны 2 байгууллагад нэвтрүүлэх	Тухай бүр	1.0 сая/тег	Сонгогдсон 2 байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэг дээшилсэн байна.	Ажлын хэсгийн гишүүд
11	Мэдээллийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудалд эрсдэлийн талаар иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	500.0 мян/төг	Арга хэмжээ зохион байгуулсан байна.	Ажлын хэсгийн гишүүд

1	2	3	4	5	6
12	"Эрхэмсэг оршихуй" эмэгтэйчүүд рүү чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Хагас жилдээ	1.0 сая/төг	Арга хэмжээ зохион байгуулсан байна.	Ажлын хэсгийн гишүүд
		Хяналт и	Палгалтын ч	чиглэлээр	
13	Экологийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааг, аюулгүй байдлыг үүсгэж болзошгүй ажиллагаанд хяналт шалгалт хийх	2-3 дугаар улиралд	-	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна	Ажлын хэсгийн гишүүд болон Экологийн цагдаагийн алба
14	Улсын онцгой объектын харуул хамгаалалтын чиглэлээр хяналт шалгалт хийх	3 дугаар улиралд	-	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн Р.Мэндбаяр Т.Хишигбаатар
15	Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг удирдамжийн дагуу зохион байгуулах	Жилд 2 удаа	1.0 мян/төг	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн Д.Сарангарав Балжинням
		Сургалт сур	талчилгаан	ы чиглэлээр	
16	Төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжоор сургалт зохион байгуулах, гарын авлага хүргүүлэх	Эхний хагас жилд	-	3-аас доошгүй сэдвээр 100- аас доошгүй албан тушаалтныг хамруулсан байна	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн Д.Сарангарав
17	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газрын үндэсний аюулгүй байдлын хариуцсан албан хаагч нарыг үндэсний аюулгүй байдал хангах чиглэлээр мэргэшүүлэх	Эхний хагас жилд	-	Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалтад хамрагдсан байна.	Үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны байнгын ажлын хэсгийн гишүүн Д.Сарангарав Р.Мэндбаяр

oQo	